



БОГД БАНК

ХУВЬЦААТ КОМПАНИ

БОГД БАНК ХК-ИЙН САНХҮҮ БОЛОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАГАС ЖИЛИЙН

ТАЙЛАН 2022



АГУУЛГА

1. Банкны тухай
2. Шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ
3. Шинээр байгуулагдсан салбарууд
4. Арга хэмжээ, нийгмийн хариуцлага
5. Санхүүгийн үзүүлэлтүүд
6. Банкны салбарын харьцуулсан үзүүлэлтүүд
7. 2022 оны тоон зорилт
8. ТУЗ-ийн бүрэлдэхүүн
9. ТУЗ-ийн дэргэдэх хороод
10. Ноогдол ашиг

БАНКНЫ ТУХАЙ

"Богд банк нь 2014 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг орчин үеийн техник технологид суурилан илүү хялбар, түргэн шуурхай хүргэх мөн цаг үеийн ач холбогдолтой арга хэмжээнд оролцох, олон улсын хамтын ажиллагааг улам өргөжүүлэн тэлэх, банкны салбарт тэргүүлэгч, нээлттэй ил тод байхын төлөө хичээн ажиллаж байна.

Бид мөн эх дэлхий, байгаль орчин болон нийгэмд ээлтэй үйл ажиллагаанд манлайлан оролцож, мөн хүүхэд залуусын ирээдүйн хөгжил, хүмүүжилд сайнаар нөлөөлөх спортын төрлүүдийг дэмжихэд бодит хөрөнгө оруулалт хийхийн төлөө зорин ажилладаг. Богд банк нь ирэх жилүүдэд засаглалын ил тод байдал, шийдвэр гаргалтад олон нийтийн саналыг тусгах, банкны системд өөрсдийн дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэвтрүүлэх, цахим шийдлийг үйл ажиллагаандаа тусгах, харилцагчийн эрэлт хэрэгцээг ухаалгаар харилцан үр ашигтай шийдвэрлэх тал дээр илүү анхааран ажиллахаар төлөвлөж байна.






Corporate gateway үйлчилгээ

“**Corporate gateway**” үйлчилгээ нь өөрийн санхүүгийн программаар дамжуулан банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломжийг олгоно.



Prime, Prime reserve кредит карт

Дэлхийн хаана ч төлбөр тооцоо хийх боломжийг харилцагчдад олгохоос гадна тусгайлсан Prime багцын үйлчилгээ, зээлийн уян хатан нөхцөл нь таны **санхүүгийн хэрэгцээг бүрэн шийдвэрлэнэ.**



V-Point цуглуулан хадгаламждаа нэмэх боломжтой

V-Point оноогоо цуглуулан зээлээ төлж, картаа захиалах, сунгах болон бусдад шилжүүлэх гэсэн үйлчилгээнүүдийг авдаг байсан бол одоо нэмэлтээр **хугацаатай хадгаламж руугаа** V Point оноогоо хөрвүүлэх боломжтой.



Хугацаатай хадгаламжаа хоногоор сонгоорой

Та заавал сар жил гэж сонгохгүйгээр өөрт тохирсон хугацаагаар хадгаламжийн хугацааг сонгох боломжтой.



Дэлхийн мөнгөний 7 хоног

Жил бүр зохион байгуулагддаг МБХ-оос зохион байгуулдаг “**Дэлхийн мөнгөний 7 хоног**” арга хэмжээнд бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулав.



IPO Mongolia 2022 forum

“*Ipo Mongolia 2022 Forum*” арга хэмжээнд Богд банк ХК нь өөрсдийн бүтээгдэхүүний үйлчилгээ болон банкны **хувьцааны талаар сонирхсон иргэдэд мэдээлэл өгч** оролцов.



Нархан асрамжийн газарт өдөрлөг зохион байгуулав

Нийгмийн хариуцлагын хүрээнд “Нархан” асрамжийн газрын хүүхэд багачуудад **эх үрсийн баярын бэлэг бэлэглэв.**



Төгөл байгуулав

“Бид банкир” ногоон ирээдүйг бүтээлцэнэ уриан дор зохиогдсон ба **“Тэрбум мод”** үндэсний хөдөлгөөний хүрээнд богд ууланд банкируудын төгөлийг байгуулав.



“Хүсэл Түгээнэ” урамшуулалт аян

Хүүхдийн эрхийг хамгаалах баярын угтан **“Хүсэл түгээнэ”** хүүхдийн хадгаламжийн урамшуулалт аяныг амжилттай зохион байгуулав.



“Итгэл Түгээнэ” урамшуулалт аян

Сар шинийн баярыг угтан **“Итгэл түгээнэ”** хадгаламжийн урамшуулалт аяныг амжилттай зохион байгуулав.




Нийслэлийн ЖДҮ-г дэмжих төвтэй хамтран ажиллав

Нийслэлийн ЖДҮ дэмжих төвтэй хамтран ЖДҮ эрхлэгчдэд цогц санхүүгийн мэдлэг олгох зорилготой **3 талт санамж бичигт** гарын үсэг зурж, хамтын ажлыг эхлүүлэв.



БШУ яамтай хамтран ажиллав

БШУЯ-аас хэрэгжүүлж буй **“Багш” картын үйлчилгээг** хэрэглээнд нэвтрүүлэх санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагааг эхлүүлэв.



Enabling Capital сантай хамтран ажиллав

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн дунд хугацааны санхүүжилтийг **Enabling Capital сангаас санхүүжилт татлаа.**



БОГД БАНК
ХУВЬЦААТ КОМПАНИ



**БИД
БАНКИР**
НОГООН ИРЭЭДҮЙГ БҮТЭЭЛЦЭНЭ

НОГООН ИРЭЭДҮЙГ ДЭМЖИНЭ



Богд банк нь “Тогтвортой Санхүүжилтийн Бодлого”-ын хүрээнд өдөр тутмын үйл ажиллагаандаа **эрчим хүчний хэмнэлт, ус болон цаасны зарцуулалтыг бууруулах, хог хаягдлын дахин боловсруулах**, нийт харилцагчид нартаа тэгш оролцоог хангасан хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхийг зорьж тусгай хэрэгцээт харилцагчиддаа зориулалтын зам болон нүдний шилийг салбар нэгжүүдэд нэмэгдүүлэн ажиллаж байна.



ЗҮҮН ДӨРВӨН ЗАМ САЛБАР
/БАЙРШИЛ ШИЛЖСЭН/



БИЗНЕС ТӨВ
/БАЙРШИЛ ШИЛЖСЭН/



УРТ ЦАГААН
ЗЭЭЛИЙН ТӨВ



ХАРХОРИН САЛБАР




ЯАРМАГ САЛБАР

ХҮҮГИЙН ОРЛОГО

/сая.төг/


ЗЭЭЛ


/сая.төг/



2022 онд нийт зээлийн багцыг 28%-аар өсгөж 202 тэрбум төгрөгт хүргэсэн байна. Энэ нь хүүгийн орлогын тогтмол өсөлттэй салшгүй холбоотой юм. Мөн чанаргүй зээлийн багцыг өмнөх оноос 0.3%-иар бууруулан эхний хагас жилд 3.3 хувьд хүргэж багцын чанарыг сайжруулах зорилтдоо хүрч чадлаа. Бид Монголбанкны КОВИД 19-ийн нөхцөлд бүтцийн өөрчлөлтийн удирдамжийн дагуу цар тахалд нэрвэгдсэн харилцагчдынхаа зээлийн нөхцөлийг цаг тухайд нь өөрчлөхөд анхаарсаар ирсэн. Манай банкны зүгээс харилцагчдын зээлийн нөхцөл өөрчлөх хүсэлтийг цахимаар хурдан шуурхай хүлээн авч харилцагчиддаа уян хатан байдлаар шийдвэрлэсэн болно.

НИЙТ ХӨРӨНГӨ


/сая.төг/



Нийт хөрөнгийн дүн **2014 онд 16.66 тэрбум төгрөг** байсан бол 2022 оны **2-р улирлын байдлаар 393.83** тэрбум төгрөгт хүрч, **2,264%**-иар нэмэгдсэн ба жилд дунджаар 52%-ийн өсөлт үзүүлжээ.

ЦЭВЭР АШИГ


/сая.төг/



2019 оноос хойш жил бүр **цэвэр ашгийн хэмжээгээ 90 орчим хувиар** нэмэгдүүлсэн байна. Энэ үзүүлэлтээс **бидний баримтлаж буй стратеги** зөв зүйтэй буюу зорилтот сегментүүдийн тогтвортой өсөлт, эрсдэлийн ухаалаг удирдлага, зардлын бүтцийг сайжруулсан, хөрөнгийн үр ашигтай зарцуулалттай холбоотой юм.

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ


/сая.төг/



Богд банк ХК нь 2016 онд харилцах хадгаламж нь 33.6 тэрбум төгрөг байсан бол 2022 оны 2-р улирлын байдлаар харилцах **хадгаламжаа 203.6 тэрбум төгрөгт хүргэж**, долоон жил зургаан сарын хугацаанд **606%-иар өсгөж чадсан ба жилд дунджаар 25%-ийн өсөлт үзүүлжээ.**

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

/сая.төг/



Богд банк ХК нь 2014 оны II-р сард үүсгэн байгуулагдаж, тухайн санхүүгийн жилээ 16.07 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэйгөөр өндөрлөсөн бол 2022 оны 2-р улирлын байдлаар өөрийн **хөрөнгөө 107.04 тэрбум төгрөгт хүргэж**, долоон жил зургаан сарын хугацаанд **665%-иар өсгөж чадсан ба жилд дунджаар 29%-ийн өсөлт үзүүлжээ.**

4.46%

АКТИВЫН ӨГӨӨЖ (ROA)

Нийт хөрөнгийн дүн 2014 онд 16.66 тэрбум төгрөг байсан бол 2022 оны 2-р улирлын байдлаар 393.83 тэрбум төгрөгт хүрч 2,264%-иар нэмэгдсэн ба жилд дунджаар 52%-ийн өсөлт үзүүлжээ.

15.41%

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ (ROE)

Хувьцаа эзэмшигчдэд хүртээх үнэ цэнийг сайжруулж, өөрийн хөрөнгийн өгөөжийг жил бүр нэмэгдүүлэн ажиллаж байна.

1.46

ОРЛОГО ЗАРДЛЫН ХАРЬЦАА

Банкны үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж зардал орлогын харьцааг сайжруулахын тулд санхүүгийн хатуу сахилга баттай бодлого баримтлан ажиллаж ирсэн.

6.17%

ЦЭВЭР ХҮҮНИЙ МАРЖИН

2022 оны эхний хагас жилд тайлант үеийн цэвэр ашиг 8.03 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 16%-иар өссөн үзүүлэлт болох ба цэвэр хүүний маржин 2021 онд 5.87% байсан бол тайлант хугацаанд 6.17% болж 0.30 функтаар өссөн. Цэвэр хүүний маржин өссөн нь хөрөнгийн үр ашигт байдал сайжирч, ашигт ажиллагаа нэмэгдсэн болохыг илэрхийлж байна.

3.68

КАПИТАЛ ҮРЖҮҮЛЭГЧ

Өөрийн хөрөнгийг нийт хөрөнгөнд харьцуулсан үзүүлэлт 2014 онд 1.04 байсан бол 2022 оны 2-р улирлын байдлаар 3.68 болж 255% өссөн нь бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн өсөлтийг харуулах бөгөөд өсөлтийн хувь их байгаа нь банкны үйл ажиллагаа өргөжин тэлж буйн илэрхийлэл болно.

44 сая.т


НЭГ АЖИЛТАНД НООГДОХ АШИГ



44 сая төгрөг буюу энэ нь өмнөх оноос 40%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Богд банк нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар төлсөн НДШ, Татварын дүн 1.7 тэрбум төгрөг / 513 сая НДШ + 1.2 тэрбумын татвар /


2022.06.30



ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	БИЕЛЭЛТ
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	9%	39%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	12%	39%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	25%	35%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа /нэгж валютаар/	15%	2%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа /нийт/	40%	2%

**АКТИВЫН ХАРЬЦУУЛСАН ИНДЕКС,
2017 ОНЫ СУУРИАР**



	Банкны сектор	100.00%	114.88%	124.15%	127.17%	142.29%	146.37%	155.40%
	Богд банк	100.00%	243.13%	334.30%	302.16%	443.18%	529.13%	643.02%



Сүүлийн таван жилийн салбарын дундаж активын өсөлт 9.22% байгаа бол Богд банкны мөн үзүүлэлт 45.09% байгаа нь салбарын дундажаас илүү өсөлт үзүүлсэн болохыг харуулж байна.

**ЗЭЭЛИЙН ХАРЬЦУУЛСАН ИНДЕКС,
2017 ОНЫ СУУРИАР**



	Банкны сектор	100.00%	123.59%	129.49%	122.04%	148.55%	167.80%	164.00%
	Богд банк	100.00%	733.19%	1128.29%	1387.72%	2026.98%	2773.30%	4300.94%



Сүүлийн таван жилийн салбарын дундаж зээлийн өсөлт 10.40% байгаа бол Богд банкны зээлийн дундаж өсөлт 112.18% байгаа нь салбарын дундажаас 10 дахин илүү өсөлттэй байна.

**ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН
ХАРЬЦУУЛСАН ИНДЕКС, 2017 ОНЫ СУУРИАР**



 Банкны сектор	100.00%	129.83%	141.10%	168.24%	190.44%	190.88%	233.71%
 Богд банк	100.00%	129.75%	311.34%	336.42%	458.20%	588.34%	670.37%

Сүүлийн таван жилийн салбарын дундаж харилцах, хадгаламжийн өсөлт 17.47% байгаа бол Богд банкны мөн үзүүлэлт 46.31% байгаа нь салбарын дундажаас илүү өсөлт үзүүлснийг илтгэж байна. Мөн депозитын өсөлтийн хувь жил бүр нэмэгдэж буй нь банкны үйл ажиллагаа өргөжин тэлж, зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж байгааг илэрхийлнэ

**ТУХАЙН ОНЫ АШИГ АЛДАГДЛЫН
ӨСӨЛТИЙН ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТ**



 Банкны сектор	100.00%	-38.53%	100.62%	114.67%	217.24%	229.76%	263.75%
 Богд банк	100.00%	155.78%	208.19%	400.07%	767.84%	572.16%	1278.16%

Сүүлийн таван жилийн салбарын дундаж татварын дараах цэвэр ашгийн өсөлт 21.41% байгаа бол Богд банкны мөн үзүүлэлт 66.46% байгаа нь салбарын дундажаас илүү өсөлт үзүүлсэн болохыг харуулж байна.

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ



Банкны сектор	7.84%	-2.88%	7.13%	7.78%	14.13%	13.38%	16.21%
Богд банк	5.01%	5.42%	5.48%	9.68%	13.22%	7.69%	14.87%



2017-2021 онд Богд банкны өөрийн хөрөнгийн өгөөж тогтмол өссөн үзүүлэлттэй байж сүүлийн таван жилийн дундаж өсөлтөөр тооцсон 2022 оны өөрийн хөрөнгийн өгөөж 14.87% гарах төсөөлөлтэй байна. Салбарын үзүүлэлтээс ялимгүй доогуур боловч тогтвортой өсөлтийг үзүүлж чадсан нь илүү сайн үнэлгээ болно. Мөн зах зээлд эзлэх хувь бага байгаа нь салбарын дундажаас доогуур байхад нөлөөлж байна.

АКТИВЫН ӨГӨӨЖ



Банкны сектор	0.93%	-0.31%	0.74%	0.80%	1.42%	1.40%	1.56%
Богд банк	2.07%	1.71%	1.36%	2.37%	3.89%	2.22%	4.44%



2017-2021 онд Богд банкны активын өгөөж тогтмол өссөн үзүүлэлттэй байж сүүлийн таван жилийн дундаж өсөлтөөр тооцсон 2022 оны активын өгөөж 4.44% гарах төсөөлөлтэй байна. Салбарын үзүүлэлтээс илүү байгаа нь активын чанар болон үр ашигт байдал илүү болохыг харуулж байна.

ОРЛОГО ЗАРДЛЫН ХАРЬЦАА




	Банкны сектор	1.08	1.07	1.06	1.07	1.16	1.31	1.19
	Богд банк	1.29	1.18	1.16	1.24	1.43	1.46	1.44

Сүүлийн таван жилийн салбарын дундаж орлого зардлын харьцааг авч үзэхэд Богд банкны үзүүлэлт салбарын үзүүлэлтээс 0.1-ээс 0.27 функтаар илүү байгаа бөгөөд 1 төгрөгийн зардал тутмаас дээрх хэмжээний илүү мөнгө олж чадаж буйг харуулж байна.

ЦЭВЭР ХҮҮНИЙ МАРЖИН


	Банкны сектор	1.23%	1.18%	1.24%	1.14%	1.58%	0.98%	1.61%
	Богд банк	7.04%	5.02%	4.87%	5.59%	5.87%	3.66%	6.18%

Банкны секторын 2017-2021 оны цэвэр хүүний маржинг авч үзвэл Богд банкны үзүүлэлт хамгийн багадаа 2.05, хамгийн ихдээ 5.81 функтаар их байгаа нь активын удирдлага салбарын үзүүлэлтээс сайн, үр ашигт байдлыг ханган ажиллаж буйг харуулж байна.

Цэвэр ашиг (2017-2021, сая.төг)

Нийт актив (2017-2021, сая.төг)

Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)

13.22%

2021Q4

Активын өгөөж (ROA)

3.89%

2021Q4

15.56%

2022Q4


4.11%

2022Q4

* Төлөвлөгөө

ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН ДУНДАЖ ӨСӨЛТИЙГ ХАДГАЛНА


Сүүлийн 4 жилд банкны нийт хөрөнгийн дундаж өсөлт 44.78% байгаа бөгөөд Банк нь ирэх жил нийт хөрөнгийн хэмжээг 54.3% буюу 179.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн нийт активын хэмжээг хагас их наяд хүргэнэ.

Нийт зээл ба чанаргүй зээлийн хувь(сая.төг)



ЗЭЭЛИЙН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАДГАЛАН ӨГӨӨЖ ӨНДӨР БҮТЭЭГДЭХҮҮН РҮҮ ЧИГЛЭН АЖИЛЛАНА.

- Банкны зээлийн багцын цэвэр өсөлтийг 150 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ.
- Үүний 70%-ийг ЖДБ-ийн зах зээлд байршуулах бөгөөд, үлдсэнг хэрэглээний зээлд буюу өгөөж өндөр, эрсдэл багатай автомашины зээлд түлхүү гаргана.
- Багцын чанарыг энэ онтой ойролцоо буюу 3.7%-д барьж ажиллана.


НИЙТ БАНКИРУУДЫН ТОО (2021-2022 ОН)



НИЙТ САЛБАРЫН ТОО (2021-2022 ОН)



ХАРИЛЦАХ ДАНС ЭЗЭМШИГЧДИЙН ТОО (2021-2022 ОН)



- Онлайн суваг, бүтээгдэхүүн үйлчилгээний сайжруулалт болон салбарын нэгжийн өсөлттэй улбаатайгаар банкны нийт харилцагчийн тоог 89%-р нэмэгдүүлэн 100,000-д хүргэнэ.
- Банкны төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа үзүүлэлтийг системийн дунджаар өндөрт хэвээр байлгах бөгөөд оны эцэст 37.3%-д барьж ажиллана.
- Ирэх жил нийт 5 шинэ салбарыг нээж үйл ажиллагаанд оруулна.

№	Нэр	Эрхэлж байгаа ажил	Томилогдсон	Төлөв
1	Л. Болдхуяг	Богд банкны ТУЗ-ийн дарга	2014.10.31	Ердийн
2	Г. Саруул	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал	2014.10.31	Ердийн
3	Жан Торстен	ТУЗ-ийн гишүүн	2018.12.31	Ердийн
4	Эллиот Рован Аукланд	ОУ-ын Хөрөнгө Оруулалтын Банкны Бизнес төлөвлөлт, санхүүгийн загварчлалын албаны дарга	2021.02.15	Ердийн
5	Ж. Нарантуяа	ОУ-ын Санхүүгийн Корпорацийн зөвлөх	2014.10.31	Хараат бус
6	Д. Моломжамц	ОУ-ын Хөрөнгө Оруулалтын Банкны зөвлөх	2018.05.09	Хараат бус
7	Э. Бямбажав	“Их Тусч” ХХК-ийн захирал, “Бодь даатгал” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн	2022.04.15	Хараат бус
8	Б.Ойгонжаргал	“Жем Интернэшнл” ХХК-ийн ерөнхийлөгч	2022.04.15	Ердийн
9	Д. Төрмандах	“Богд Банк” ХК-ийн ерөнхий аудитор	2020	Аудиртор



Л. БОЛДХУЯГ
ТУЗ-ийн дарга



Г. САРУУЛ
ТУЗ-ийн гишүүн,
Гүйцэтгэх захирал



Ж. НАРАНТУЯА
ТУЗ-ийн хараат бус
гишүүн,



Э. БЯМБАЖАВ
ТУЗ-ийн хараат бус
гишүүн,



Д. МОЛОМЖАМЦ
ТУЗ-ийн гишүүн,



ЖАН ТОРСТЭН ДАЗЕР
ТУЗ-ийн гишүүн



ЭЛЛИОТ РОВАН АУКЛАНД
ТУЗ-ийн гишүүн,



Б. ОЙГОНЖАРГАЛ
ТУЗ-ийн гишүүн



Д. ТӨРМАНДАХ
Ерөнхий аудитор

Банкны ТУЗ нь доорхи 4 үйл ажиллагааны хороог хариуцан удирддаг. **Үүнд:**

- **Урамшууллын хороо**
- **Эрсдэлийн удирдлагын хороо**
- **Аудитын хороо**
- **Хүний нөөцийн хороо**

АУДИТЫН ХОРОО

Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайлангийн үйл явц, дотоод хяналтын систем болон санхүүгийн эрсдэлийн менежмент, аудитын үйл явц, комплайнс буюу хуулийн нийцлийн асуудлыг хянах үйл явцыг холбогдох хууль тогтоомж, Банкны дотоод дүрэм, журмын дагуу хянахад ТУЗ-д дэмжлэг үзүүлэн ажилладаг. Энэхүү хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Нарантуяа, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Моломжамц нар ажиллаж байна.

УРАМШУУЛЛЫН ХОРОО

Урамшууллын хороо нь Банкинд мөрдөгдөж буй цалин урамшууллын бодлогын хэрэгжилт, гүйцэтгэх удирдлагын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний биелэлт, ёс зүйн хэм хэмжээ болон банкны урт хугацааны ашигт ажиллагаатай уялдуулсан эсэхэд хяналт тавих, ТУЗ, гүйцэтгэх удирдлагад олгох цалин урамшууллын хэмжээг тодорхойлж, ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушуултны үйл ажиллагааг идэвхжүүлэх үүрэгтэй. Тус хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Моломжамц, гишүүдээр ТУЗ-ийн дарга Д.Болдхуяг, ТУЗ-ийн гишүүн Торстен Дазер нар байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Эрсдэлийн удирдлагын хороо нь Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, хянах замаар Банкны хүлээж болзошгүй хохирлыг бууруулах, эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгон хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Моломжамц, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг, ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Саруул нар ажиллаж байна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХОРОО

Хүний нөөцийн хороо нь ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүнг дүгнэж, ажлын гүйцэтгэлийн тайланг хувьцаа эзэмшигчдэд жил бүр, ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын гүйцэтгэл, хурлын ирц, хуралд оролцсон байдлын талаар ТУЗ-д тус тус тайлагнах, ТУЗ-ийн гишүүнийг томилох, үүрэг ажлаас чөлөөлөх асуудлыг ХЭХ-д оруулах, гүйцэтгэх удирдлагад багтан ажиллах албан тушаалтныг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх этгээдийг ТУЗ-д танилцуулах, гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэл болон гэрээний биелэлтийг дүгнэж ТУЗ-д танилцуулах зэрэг үүрэгтэй ажилладаг. Хүний нөөцийн хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Нарантуяа, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг болон ТУЗ-ийн гишүүн Г.Саруул нар ажиллаж байна.



НООГДОЛ АШИГ

Эдийн засгийн хамгийн нөлөө бүхий салбар болох банк, тэр дундаа хувийн эзэмшлийн арилжааны банкнууд үүсэн бий болсон цагаас хойших анхны томоохон реформыг хийж чадсан “Богд банк” ХК 2021 оны 12 дугаар сарын 01-нд анхдагч IPO арилжаагаа олон нийтэд нээлттэй зарлаж, төлөвлөгөөгөө **104.5** хувиар биелүүлэн, **31.75** тэрбум төгрөг татан төвлөрүүлснээс хойш Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 22/63 тоот тогтоолын дагуу 2022 оны хоёрдугаар улирлын татварын дараах цэвэр ашгаас ногдол ашгаа тараахаар боллоо.

Тус банкны 2022 оны хоёрдугаар улирлын цэвэр ашиг нь **8,033,500,938.79** төгрөг бөгөөд үүний 15 хувь болох **1,205,025,140.82** төгрөгийн ногдол ашгийг нийт эргэлтэд байгаа **62,500,000.00** ширхэг хувьцаанд ногдуулан мөнгөн хэлбэрээр хуваарилахаар болсон бөгөөд нэгж хувьцаанд **19.28** төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн байна.





БОГД БАНК

ХУВЬЦААТ КОМПАНИ

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

ИТГЭЛ ТҮГЭЭНЭ